



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 031

Пионер толгой

“Энэ жилдээ эрүүл жиндээ” аян  
зохион байгуулах ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.1, 2.2.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Энэ жилдээ эрүүл жиндээ аян”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Сүхбаатар	Эрүүл мэндийн төвийн дарга
Гишүүд:	Э.Цэрэнханд	Цэцэрлэгийн эрхлэгч
	Б.Бадамцэцэг	Соёлын төвийн дарга
	Б.Мөнхдалай	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Эрдэнэ-Очир	Биеийн тамирын арга зүйч
	Ц.Орхонтуул	Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан
	Д.Зундуйжамц	Биеийн тамирын багш
	Б.Пүрэв	Бүжгийн багш
	Д.Мөнхзул	Ерөнхий боловсролын сургуулийн эмч
Нарийн бичгийн дарга:	Т.Цагаанлянх	Эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтан

2. Аяны хүрээнд байгууллага бүр албан хаагчдаараа “Түмэн дасгал”-ыг хийж хэвшүүлэхийг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. “Энэ жилдээ-Эрүүл жиндээ аян”-ыг ард иргэд, албан хаагчдын дунд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж хэрэгжилтийг сар бүр засаг даргын Удирдлагын багийн хуралд тайлагнаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Сүхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА 642201239